



3139

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Д.МӨНХСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442273

Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn  
Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2022.08.26 № 8/1426

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

*Т/м дарга Д. Дамсүрэн*  
*Зөвлөмжөө хүргэж*  
*амжилна*  
*2022.09.02*

Засгийн газрын үйл ажиллагааны  
хөтөлбөрийн хэрэгжилтэд  
зөвлөмж өгөх тухай

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймагтай холбоотой зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг тооцох, орон нутагт гарсан үр нөлөөг үнэлэх зорилгоор хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 18 зорилт, арга хэмжээнээс үр дүнтэй хэрэгжсэн 100% -3, 70% -3, эрчимжүүлэх шаардлагатай 50% -6, 30% -6 заалт байна. Хэрэгжилтийн дундаж 55% байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс тодорхой үр дүн гарч байгаа боловч “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу “Үр дүнгүй”, цаашид бодлогын түвшинд авч хэлэлцэн төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжүүлэх шаардлагатай 6 зорилт, арга хэмжээ байна. Үүнд:

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.6.2 дахь заалт “Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ”

2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.9.2 дахь заалт “Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ”

3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.9.8 дахь заалт “Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна”

4. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.4.1 дэх заалт “Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ”

*М. Интшааг*  
*ЗТ-н үгч-ны хөт-г*  
*Бүрэн хангам амжилт*  
*алхаар баян хөгжилд*  
*нигэд хүргүүлэх,*  
*А/Зүйн зөвлөснөөс олох, үзв-г хэрэгт-лэх*  
662201208  
Тамгын газрын А-4 тоот 2022 он  
*2022.09.02*

5. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8.1 дэх заалт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ”

6. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.10.1 дэх заалт “Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна” гэсэн зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилт удааширалтай буюу хэрэгжээгүй байна.


Иймд дараах зөвлөмжийг өгч байна.

1.“Эрчимжүүлэх шаардлагатай буюу “Үр дүнгүй” 6 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар бодлого, төлөвлөгөө, шийдвэр гаргаж хэрэгжилтийг зохион байгуулах;

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт бүрийг Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хагас, бүтэн жилээр дүгнэж байх;

3.Төрийн албан хаагч бүр тайлагналтад анхаарч, тайлангийн утга найруулгад анхаарч, эцсийн болсон тайланг хэлтсийн даргаар хянуулж, ирүүлж байх;

4.Тайланг илгээхдээ хийсэн ажлын нотлох баримт, зураг, тайлан, илтгэх хуудас зэрэг хавсралт файл ирүүлж байхыг зөвлөмж болгож байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА  Л.МАНДАЛ

